

МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Онцгой албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.12, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Импортоор оруулсан болон Монгол Улсад үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлшний албан татварыг хураан авах, төсөвт төлөх журмыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэ тушаалыг баталсантай холбогдуулан Сангийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 211 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар (Б.Ариунсан), Гаалийн ерөнхий газар (О.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаалыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД  Б.БОЛОР

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ  
ХУУЛБАР ҮНЭН  
Бүртгэлийн № 159  
Төрийн захиргаа, орон нутгийн газрын дарга  
Архивын эрхлэг  
Минт 8 хуудас 2015 оны 12 сарын 15 өдөр

Сангийн сайдын 2015 оны 1.2 дугаар  
сарын 11-ны өдрийн 334 дугаар  
тушаалын хавсралт

**Импортоор оруулсан болон Монгол Улсад үйлдвэрлэн борлуулсан  
автобензин, дизелийн түлшний албан татварыг  
хураан авах, төсөвт төлөх журам**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Энэхүү журмын зорилго нь импортоор оруулсан, Монгол Улсад үйлдвэрлэн борлуулсан автобензин, дизелийн түлш (цаашид “бүтээгдэхүүн гэх”) - нд салбарын онцлог харгалзан тогтоосон онцгой албан татвар, гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид “албан татвар” гэх)-ыг хураах, баталгаажуулах, төсөвт төлөх, тайлагнах, эдгээрт хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Албан татвар ногдох бүтээгдэхүүнийг тодорхойлох**

2.1 Автобензин, дизелийн түлшийг импортолж байгаа эсхүл Монгол Улсад үйлдвэрлэн борлуулж буй этгээд (цаашид “албан татвар төлөгч” гэх) ийнхүү импортолсон болон үйлдвэрлэн борлуулсан бүтээгдэхүүнээ Засгийн газраас тогтоосон салбарын онцлогоор нь ангилан гааль, татварын байгууллагад мэдүүлж, тайлагнана. Гаалийн мэдүүлэг, татварын тайланд Засгийн газраас тогтоосон онцлог салбарын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдэд борлуулах, нийлүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г хавсаргасан байна.

2.2 Албан татвар төлөгч нь бүтээгдэхүүний борлуулалт, нийлүүлэлтийн мэдээг энэ журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу гаргаж, Гэрээ, холбогдох бичиг баримтын хамт Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд хавсарган Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хугацаанд харьяалах татварын албанд хүргүүлнэ.

2.3 Засгийн газраас тогтоосон онцлог салбарт үйл ажиллагаа эрхэлж албан татвар төлөгч нь тухайн үйл ажиллагаанд зориулж импортолсон болон худалдан авсан бүтээгдэхүүний мэдээг энэ журмын 3, 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж, сар бүрийн 10-ны дотор Татварын ерөнхий газарт хүргүүлнэ.

**Гурав. Албан татварыг хураан авах, төсөвт төлөх**

3.1 Албан татварыг дараах байдлаар хураан авч, төсөвт төвлөрүүлнэ:

3.1.1 Импортын бүтээгдэхүүний онцгой албан татварыг Онцгой албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10, 8.11 дэх хэсэгт заасны дагуу

гаалийн байгууллага ногдуулан хураан авч, тухай бүр төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

3.1.2 Импортын бүтээгдэхүүний гаалийн албан татварыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 35, 36, 39 дүгээр зүйлд заасны дагуу гаалийн байгууллага ногдуулан хураан авч, тухай бүр төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

3.1.3 Импортын бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татварыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу гаалийн байгууллага ногдуулан хураан авч, төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

3.1.4 Албан татвар төлөгч нь Монгол Улсад үйлдвэрлэн борлуулсан бүтээгдэхүүний онцгой албан татварыг татварыг Онцгой албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэгт заасны дагуу төлж, тайлагнана.

3.1.5 Албан татвар төлөгч нь Монгол Улсад үйлдвэрлэн борлуулсан бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн албан татварыг татварыг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх хэсэгт заасны дагуу төлж, тайлагнана.

#### **Дөрөв. Албан татварын ногдол, төлөлтийг хянах**

4.1 Энэ журмын 2.2, 2.3-т заасны дагуу мэдүүлсэн албан татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан, борлуулсан болон худалдан авсан бүтээгдэхүүний мэдээ, Гэрээ, бусад баримт бичгийг үндэслэн тухайн албан татвар төлөгчийн тайлант хугацаанд Засгийн газрын онцлог салбарт зориулан борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ, өртөг, түүнийг нийлүүлсэн хуулийн этгээдийг Татварын ерөнхий газар хянаж, тодорхойлно.

4.2 Энэ журмын 4.1-д заасны дагуу тодорхойлсон мэдээний нэгтгэлийг Татварын ерөнхий газар тухайн сарын 15-ны өдрийн дотор Гаалийн ерөнхий газар, Сангийн яаманд хүргүүлнэ.

4.3 Татварын ерөнхий газраас хүргүүлсэн мэдээллийг Гаалийн ерөнхий газар энэ журмын 2.1-д заасан гаалийн мэдүүлэг, бусад баримт бичигтэй тулган албан татвар төлөлтөд хяналт тавина.

4.4 Татварын ерөнхий газар энэ журмын 4.1-д заасан мэдээлэлд үндэслэн Засгийн газраас салбарын онцлог харгалзан тогтоосон салбарын хэрэгцээнд борлуулсан Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлтөд хяналт тавина.

4.5 Албан татварын дутуу төлөлтийг нөхөн төлүүлэх, илүү төлөлтийг суутгах, буцаан олгох асуудлыг татвар, гаалийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


4.6 Энэ журмын 2.1-д заасан мэдүүлэг, татварын тайлангийн үнэн зөв эсэх, мэдүүлсэн бүтээгдэхүүний зориулалтын дагуу ашигласан эсэхэд татвар, гаалийн байгууллага хяналт тавина.

#### **Тав. Бусад**

5.1 Гаалийн болон татварын байгууллагад мэдүүлэх гэрээ, холбогдох баримт бичгийн үнэн зөвийг албан татвар төлөгч, ногдуулсан албан татварын дүнг хянаж баталгаажуулсан гаалийн болон татварын байгууллага, ажилтан хариуцна.







Сангийн сайдын 2015 оны 14 дугаар сарын 14-  
ны өдрийн 334 дугаар тушаалаар баталсан  
журмын 3 дугаар хавсралт


**Засгийн газраас тогтоосон салбарт үйл ажиллагаа эрхлэгчийн худалдан авсан  
автобензин, дизелийн түлш (бүтээгдэхүүн)-ний зардлын мэдээ**

Албан татвар төлөгчийн нэр: .....

Албан татвар төлөгчийн бүртгэлийн дугаар: .....

Тайлант хугацаа:.....

Д/Д	Бүтээгдэхүүн борлуулсан, нийлүүлсэн этгээд		Худалдан авсан бүтээгдэхүүний төрөл (тонн)		
	Бүртгэлийн дугаар	Нэр	90 хүртэл октантай автобензин	90-ээс дээш октантай автобензин	Дизелийн түлш
А	Б	В	Г	Д	Е



Сангийн сайдын 2015 оны 14 дугаар сарын 14  
ны өдрийн 234 дугаар тушаалаар баталсан  
журмын 4 дүгээр хавсралт

**Засгийн газраас тогтоосон салбарт үйл ажиллагаа эрхлэгчийн импортолсон  
автобензин, дизелийн түлш (бүтээгдэхүүн)-ний зардлын мэдээ**

Албан татвар төлөгчийн нэр: .....

Албан татвар төлөгчийн бүртгэлийн дугаар: .....

Тайлант хугацаа:.....

Д/Д	Бүтээгдэхүүний төрөл	Өөрийн нөөц бүрдүүлэх зорилгоор шууд импортлосон бүтээгдэхүүний нийт дүн /тн/		Гаалийн байгууллагад төлсөн албан татвар		
		Тайлант хугацаа	Өссөн дүн	Онцгой албан татвар	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Гаалийн албан татвар
А	Б	В	Г	Д	Е	Ж